



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/118

Есөнбулаг сум

Дэд зөвлөлийг шинэчлэн байгуулах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дэд зөвлөлийн дарга: (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
(Алтайн бичил уурхайчдын эв нэгдлийн холбооны тэргүүн)

(Миний Алтай телевизийн захирал)

(Иргэний нийгмийн байгаль орчны зөвлөлийн тэргүүн)

(“Хан-Алтай ресурс” ХХК-ийн орон нутаг хариуцсан мэргэжилтэн)

(“Сэкер ресурс монголиа” ХХК-ийн төлөвлөлтийн инженер)

(“Рагнарок инвестмент” ХХК-ийн байгаль орчин орон нутаг хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтсийн геологи, уул уурхай, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн)

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах, санаачилгыг хэрэгжүүлэх, нээлттэй мэдээлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг дэд зөвлөл (Засаг даргын орлогч)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/172 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

8000210150